



“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төсөл

2011 он 12 сарын 8

Төслийн мэргэжилтэн
Сүзүки Саяака
Бадамсамбуу Хишигбаяр

Агуулга

- 1.Суралцахуйд суурилсан багшлах арга зүй гэж юу вэ?
2. Японы багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын тогтолцоо (видео)
3. Хичээлийн судалгаа гэж юу вэ?
 - Хичээлийн судалгааны түүх ба үндэслэл
 - Хичээлийн судалгааг хэрхэн хийх вэ ? (видео)
- 4.“Сургууль төвтэй хичээлийн судалгаа”-ны танилцуулга



1. Суралцахуйд суурилсан багшлах арга зүй гэж юу вэ?

- Суралцахуй гэж юу вэ?
 - Хүүхэд өөрийн бие даасан, бүтээлч ү/а-аар шинэ зүйлийг танин мэдэх чадвар эзэмших
- Суралцахуйг хэрхэн дэмжих вэ? - Багшлахуй
 - Суралцахуйг дидактик шийдлээр (сэдэлжүүлэх, урамшуулах, чиглүүлэх г.м) дэмжих багшийн ү/а
- Суралцахуйг дэмжих багшлах арга зүйг хэрхэн хөгжүүлэх вэ?
 - Багшийн зөвлөмж /Хичээлийн судалгаа/
 - Сургалт /Хичээлийн судалгаа/

1. Суралцахуйд суурилсан багшлах арга зүй гэж юу вэ?

- Багшлах аргын хувьд шинэ арга барил биш
- Хэрэгжүүлсэн хугацаа:
 - Европын орнуудад 1800 жил
 - Японд 1920-1930 оны үед
- “Хүүхэд төвтэй арга зүй Монголд 20-иод жилийн өмнөөс дэлгэрсэн (шинэ зүйл биш)” гэж ярихыг сонссон.

1. Суралцахуйд суурилсан багшлах арга зүй гэж юу вэ?

- Дуусах хугацаа: ? ? ?



Завхан аймгийн
Завханмандал суманд,
“Амьтдын хөдөлгөөн” хичээл



5-р ангийн Хүн Байгалийн хичээл





Багануур дүүргийн
Боловсрол цогцолбор
сургуульд

Хүн Байгалийн хичээл
“Бодисын шинж чанар ~
Бодисын нягт~” хичээл



Нсрын 2

Бодис бүр масс адил уу? өөр үү?

<танинх>

Орц
Хүнийн бие

Хүнийн бие
Хүнийн бие
Хүнийн бие
Хүнийн бие

Орц
Хүнийн бие
Хүнийн бие
Хүнийн бие
Хүнийн бие

Орц
Хүнийн бие
Хүнийн бие
Хүнийн бие
Хүнийн бие

Орц
Хүнийн бие
Хүнийн бие
Хүнийн бие
Хүнийн бие

<туршилт>

Сүү ба Ус
Зэс ба Моног
Моног ба Мод

<ойлгосон>

<дүгнэлт>

Хүнийн масс **Нэгт** хэв
шүүд хамааралтай
Масс багатай $\rightarrow$ Нэгт багатай
Масс ихтэй $\rightarrow$

Орц гэж боддог
байна халаар
сүү нь өтгөн
нь ихтэй
нь ихтэй
багатай

Орц
Хүнийн бие
Хүнийн бие
Хүнийн бие
Хүнийн бие

Орц гэж боддог байна халаар гэж сүү
нь өтгөн, ус нь ихтэй, мөн өрц нь юм
жишээний өрцөө өтгөн,
(Туршилт)

Ус ба (сүү)
Зэс ба Моног
Моног ба Мод

(сүү, ус хоёр өрц) (ойлгосон маш сайн).
Зэс ба моногийн жишээг үзвэл тэд
нь зүүд. Моног ба модон жишээг мөн
нь тэдгэр нь зүүд тийш и урлаас масс, мөн
нь өрц. Мөн
(дүгнэлт)
Хүнийн масс нэгт хоёр шүүд хамаарал
тай

Масс багатай $\rightarrow$ Нэгт багатай
Масс ихтэй $\rightarrow$ Нэгт мөн и ихтэй.
Гэвч хэвээрээ гэсэн тэдгэр багатай
даа багатай

Бүхт өрц, өрц нэгтэй. Бодисын нэгтэй шийтгэл
Хүнийн хэв ба тивэх шийтгэл тийш
мөн байна.

Хүнийн масс, нэгт хоёр шүүд хамааралтай
Нэгт ихтэй бодис нь масс ихтэй, зүүд байдаг
Нэгт багатай бодис нь масс багатай, хэв
байдаг.

11-р сарын 23 нд.
Бодис бүр масс адил байдаг уу? өөр үү?



Булган аймгийн
Сэлэнгэ сумын
сургуулд

Дунд ангийн
математикийн
хичээл





Булган аймгийн Хутаг-Өндөр сумын сургуульд
Төсөлт ажил хичээл

1. Суралцахуйд суурилсан багшлах арга зүй гэж юу вэ?

- Бид, хүүхдүүд хичээлдээ сонирхолтой хандаж, хичээлээ сайн ойлгож, асуудлыг шийдвэрлэж чадахуйц “Суралцахуй”-г дэмжих арга зүйг Монгол орон даяар түгээн дэлгэрүүлэхээр зорин ажиллаж байна.

2.Японы мэргэжил дээшлүүлэх ТОГТОЛЦОО

- Үндэсний түвшинд
- Орон нутгийн түвшинд
- Сургуулийн түвшинд
 - Хичээлийн судалгаагаар дамжуулан багшийн арга зүйг сайжруулах

3. Хичээлийн судалгааг хэрхэн хийх вэ?

- Хичээлийн судалгааны түүх ба үндэслэл -

- Хичээлийн судалгааг Японд 100-аад жилийн өмнөөс хийж эхлэсэн.
- Хичээлийн судалгааг хийх болсон үндэслэл:
 - 1) Бага сургуулийн багш нар бүх судлагдахуунаа хариуцдаг байсан нь учир, өөр хоорондоо харилцан зөвлөлдөж мэдээллээ солилцохын суурь үндэс нь тавигдсан байсан гэж үздэг.
 - 2) Дайны дараа, сургуулиудад түшиглэн хөтөлбөр боловсруулах ажлыг зохион байгуулах болж, сургуулийн түвшинд түгээн дэлгэрүүлэх явдлыг чөлөөтэй болгосон. Гэвч, суралцах чадвар буурсан байна.
 - 3) Боловсролыг орчин үед нийцүүлэн хөгжүүлэх болсон цагаас улсын хэмжээнд нэгдсэн нэг боловсролын агуулгыг түгээн дэлгэрүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон.

3. Хичээлийн судалгааг хэрхэн хийх вэ?

- Хичээлийн судалгааны түүх ба үндэслэл

- Япон Улс ч, дэлхийн 2-р дайны дараа багш төвтэй, мэдлэгт суурилсан сургалтыг хэрэгжүүлж байсан.
- Гэсэн хэдий ч, байгалийн ухаан болон математикт дургүй, суралцахуйн агуулгыг ойлгодоггүй хүүхдүүд олноор бий болж байсан байна.

3. Хичээлийн судалгаа гэж юу вэ?

- Хичээлийн судалгааны түүх ба үндэслэл -

- Урьд өмнө (Мэйжигээс Тайшёогийн эхэн үе хүртэл) “Мэдлэг дамжуулах хэлбэрийн (мэдлэгт суурилсан) хичээл”-ээр дамжуулан “Их хэмжээний мэдлэгийг хэрхэн үр өгөөжтэйгээр хүүхдэд дамжуулах вэ?” гэдэгт анхаарал хандуулдаг байв.
- Эдүгээ, “Бүтээлч мэдлэг эзэмших арга барилд биечлэн суралцах хэлбэрийн хичээл” зохион байгуулахыг зорин, “Явал хүүхдэд бүр өөрсдөө бусадтай харилцах явцдаа мэдлэг эзэмших арга барилд биечлэн суралцах вэ?” гэдгийг гол анхаарлынхаа төвд байлгах болсон.

3. Хичээлийн судалгаа гэж юу вэ?

- Хичээлийн судалгааны үндэслэл

- Дээрхи байдалдаа дүгнэлт хийн:

1977 оноос: Мэдлэгийн суурь, үндсийг тавихад анхааран, сургахад яарахгүй байх арга хэлбэрийг нэвтрүүлсэн.

1989 оноос: Хүүхдийн хүсэл сонирхол, хувийн онцлогт анхаарч эхэлсэн.

1998 оноос: “Ажиллаж, амьдрах чадвар”-ыг хөгжүүлж эхэлсэн...

- Багшийн арга зүйг сайжруулах бэлэн арга гэж байдаггүй.
- Багш нар хүүхдүүддээ хэрхэн улам сайн боловсрол олгох вэ хэмээн үргэлж тунгаан, дахин давтсаар туршлага хуримтлуулдаг.

3. Хичээлийн судалгаа гэж юу вэ?

- Хичээлийн судалгааны түүх ба үндэслэл -
 - 1990 онд АНУ-ын бага ангийн математикийн хичээлд энэхүү арга зүй шинээр нэвтэрч эхэлсэн. (Өнөөдөр хичээлийн судалгааг янз бүрийн орон өөр хоорондоо ялгаатай байдлаар зохион байгуулж байна.)
 - ЖАЙКА-гийн Байгалийн ухаан, математикийн боловсролын төслөөр дамжин Ази, Африкийн орнуудад хэрэгжих болсон.

3. Хичээлийн судалгаа гэж юу вэ?

“Хичээлийн судалгаа”: Хичээлийн бэлтгэл судалгаа, хичээл заах/ажиглах, хэлэлцүүлэг хийх гэсэн 3 алхамаар дамжуулан **арга зүйн судалгаа** хийх явдал юм.

- Зорилго:** Хүсэл санаачлагатай багшийн боловсруулсан шинэ арга зүйг бусад багш нарт танилцуулан, **аль болох олон багш** хичээлдээ хэрэгжүүлэх замаар арга зүйгээ сайжруулах зорилгоор хийдэг.

- Үр дүн:** Оролцогч багш нар хичээлийн судалгаагаар дамжуулан сургалтын **материал** сонгон хэрэглэх чадвар, хүүхдээ **ажиглах** чадвараа хөгжүүлэхийн зэрэгцээ багш нар хоорондын **хамтын ажиллагааг** бэхжүүлэх бололцоотой.

3. Хичээлийн судалгаа гэж юу вэ?

- Хичээлийн судалгааны алхам -

Хичээлийн судалгааны цикл

- 1) “Хичээлийн бэлтгэл судалгаа”-нд тулгуурласан хичээлийн бэлтгэл
- 2) Судалгаат/судлагдах хичээл заах, ажиглах
- 3) Хичээлийн дараахи нэгдсэн хэлэлцүүлэг
- 4) Арга зүйгээ сайжруулах, тайлан боловсруулах



Хичээлийн судалгааны
дараагийн цикл рүү

3. Хичээлийн судалгаа гэж юу вэ?

- Хичээлийн судалгааны алхам -

1) “Хичээлийн бэлтгэл судалгаа”-нд тулгуурласан
хичээлийн бэлтгэл

Хичээлээ төлөвлөх

- Жилийн төлөвлөгөө
 - Нэгж хичээлийн төлөвлөгөө
 - Ээлжит хичээлийн хөтөлбөр (1 цагийн хичээлийн)
- * Судалгаат хичээлийн үед, сургуулийн сургалтын зорилго зорилт, хичээлийн жилийн төлөвлөгөө, нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт уялдсан “Ээлжит хичээлийн хөтөлбөр” боловсруулна.
- * * Ердийн хичээлд товч хичээлийн хөтөлбөр ашигладаг.

“Тухайн цагийн хичээлийн хөтөлбөр” боловсруулахдаа

- Зорилгоо тодорхой болгох.
- Хичээлийн зорилтот бүлэг буюу хүүхдийг ойлгож мэдрэх.
⇒ Арга зам тодорхой болно.

Хичээлийн хөтөлбөрийн үүрэг

Хичээл явуулж багшийн хувьд:

- Хичээлийнхээ бүтцийг тодорхой болгох
- Хичээлийн зорилго болон хичээлийг хэрхэн зохион байгуулах
- “Хүүхдийн хандлага”-ыг тооцон түүнд тохирсон аргаа сонгох
- Сургалтын материалыг хэрхэн үр дүнтэй ашиглах
- Шинэ арга зүйгээ хэрхэн бодитой болгох вэ гэх зэрэгт хэрэглэгддэг

Хичээл ажиглагч багшийн хувьд:

- Хичээлийн тухай урьдчилан ойлголт авах
- Шинэ арга зүйг үр дүнтэй хэрэглэх
- Шинэ арга зүй аль болох олон багш нарт түгээх зорилготой

3. Хичээлийн судалгаа гэж юу вэ?

- Хичээлийн судалгааны алхам -

2) Судалгаат/судлагдах хичээл заах, ажиглалт хийх

Хичээлд ажиглалт хийхэд анхаарах зүйлс

- Хичээлийн зорилго
- Хичээлийн сэдэлжүүлэлт
- Хүүхдэд тавих асуулт
- Хүүхдийн хариу үйлдэл, бүдэрч буй байдал
- Хичээлийн үед хүүхдийг идэвхижүүлэх
- Хүүхдээс гарч буй санаа бодлыг олж харах арга
- Хичээлийн дүгнэлт

3. Хичээлийн судалгаа гэж юу вэ?

- Хичээлийн судалгааны алхам -

3) Хичээлийн дараахи нэгдсэн хэлэлцүүлэг

- Хэлэлцүүлэг нь хичээлийг удирдаж явуулсан багш, ажиглагч багш, зөвлөх багш ярих гэсэн дарааллаар явагдана.
- Хичээл удирдсан багш нь хичээлийнхээ зорилгын дурьдаж, дутагдалтай тал болон сайн тал гэх зэргээр саналаа ярина.
- Ажиглагч багш нар, түүнийг сонссоны дараа хийсэн тэмдэглэлдээ тулгуурлан асуулт асууж, сайжруулах зүйлээ онцлох, саналаа хэлэх гэх мэтээр хэлэлцүүлгийг өрнүүлнэ.
- Эцэст нь зөвлөх багш (их дээд сургуулийн багш, мэргэжилтэн, сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч) ерөнхийд нь зөвлөгөө өгнө.

3. Хичээлийн судалгаа гэж юу вэ?

- Хичээлийн судалгааны алхам -

3) *Хичээлийн дараахи нэгдсэн хэлэлцүүлэг*

- **Хөтлөгч багшийн үүрэг:** Тухайн хичээлийн зорилго зорилтыг тодруулан, хэлэлцүүлгийг ач холбогдолтой явуулахад анхаарна. Ажиглагч багш нарын яриа, санал цөөдөж байвал, асуудал дэвшүүлэн хэлэлцүүлгийг өрнүүлэх үүрэгтэй. Мөн, хөтлөгч багшийг урьдчилан сонгосон байх нь зохимжтой бөгөөд хэн дуртайгаараа хөтлөгч хийлгэнэ гэсэн үг бас биш юм.
 - **Ажиглагч багшийн үүрэг:** Хичээл эхлэхийн өмнө хичээлийн хөтөлбөртэй танилцан, хичээлийн зорилго зорилтыг тодруулан, анзаарсан зүйлээ хичээлийн хөтөлбөрт тэмдэглэн, түүнийхээ талаар хэлэлцүүлгийн үед асуух зэргээр оролцох ба олж мэдсэнээ аль болох өөрийнхөө хичээлд ашиглахыг эрмэлзэх.
- * Хичээл заасан багшийг шүүмжилсээр байгаад дуусгаж болохгүй. Бүтээлч санал хэлэхэд санаа тавин оролцох шаардлагатай. Багшийг үнэлэх, дүгнэх биш арга зүйг сайжруулахад анхаарах

3. Хичээлийн судалгаа гэж юу вэ?

Бэлтгэл	Хичээл заах, сайжруулах	
Бэлтгэл	Хичээл заах, сайжруулах	
Бэлтгэл	Хичээл заах, сайжруулах	
Бэлтгэл	Хичээл заах, Ажиглах	Хэлэлцүүлэг
Бэлтгэл	Хичээл заах, сайжруулах	
Бэлтгэл	Хичээл заах, сайжруулах	
Бэлтгэл	Хичээл заах, сайжруулах	
Хөтөлбөр боловсруулах	Хөтөлбөрийн хэрэгжилт, сайжруулалт	

1. Арга зүйгээ сайжруулах – Хичээлийн судалгааг \Жюгёо кэнкю\ хэрэгжүүлэх, сургуулийн үйл ажиллагаанд хэвшүүлэх
2. Арга зүйгээ сайжруулах – Хичээлийн бэлтгэл судалгааг \Кёзай кэнкю\ тогтмол хийх(зөвхөн Хичээлийн судалгаанд биш), багш бүр өөрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх


4. “Сургууль төвтэй хичээлийн судалгаа”-ны танилцуулга

“Сургууль дээрхи судалгаа”

1. Бүх сургуулиуд сургалтын зорилтоо биелүүлэхийн тулд сургуулийнхаа хэмжээнд нийтлэг сэдэв сонгон хичээлийн судалгаа зохион байгуулдаг.
2. Тодорхой нэг судлагдахуунаар хичээлийн судалгаа зохион байгуулахаас гадна бүх судлагдахуунд ч нэгэн зэрэг зохион байгуулах тохиолдол ч бий.
3. Жишээ нь “Хүүхдүүддээ харилцааны чадвар суулгая” гэсэн сэдэв сонгосон бол бүх судлагдахуунаар нэгэн зэрэг хичээлийн судалгаа зохион байгуулж болно.
4. Хичээлийн судалгааг сургуулийн зорилгод хүрэхэд идэвхитэй ашигладаг.

4. “Сургууль төвтэй хичээлийн судалгаа”-ны танилцуулга

1) “Сургууль төвтэй хичээлийн судалгаа”-г хийх бүтэц зохион байгуулалт (жишээ)



4. “Сургууль төвтэй хичээлийн судалгаа”-ны танилцуулга

2) “Сургууль төвтэй хичээлийн судалгаа”-ны хөтөлбөр (жишээ)

- ◎ 2-3 жилд нэг судалгааны сэдвээр хамтран ажилладаг.
- ◎ Жилийн үйл ажиллагаа

4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар
Судалгааны нэгдлийн хурал	Судалгааны нэгдлийн хурал (Тухайн жилийн сэдэв сонголт)	Гадны сургагч багшийн лекц	Судалгааны нэгдлийн хурал (Хэрэглэгдэхүүн, сургалтын материал)		Судалгаат хичээл	Судалгаат хичээл (2 удаа)	Судалгааны тайлангаа хэлэлцүүлэх	Судалгаат хичээл (2 удаа)	Судалгаат хичээл	Судалгааны нэгдлийн нэгдсэн хурал (Тухайн жилийн судалгаагаа дүгнэх)	Судалгааны нэгдлийн нэгдсэн хурал (Дараа жилийн судалгааны талаар хэлэлцэх)

4. “Сургууль төвтэй хичээлийн судалгаа”-ны танилцуулга

2) “Сургууль төвтэй хичээлийн судалгаа”-ны хөтөлбөр (жишээ)

◎ 1 долоо хоногийн үйл ажиллагаа

Ням	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба
	Хичээлийн дараа анги бүлгээрээ цуглаан хийх	Багш бүр хичээлийн бэлтгэл судалгаагаа хийх	Багш бүр хичээлийн бэлтгэл судалгаагаа хийх		Нийт багш нарын цуглаан	

4. “Сургууль төвтэй хичээлийн судалгаа”-ны танилцуулга

Жишээ: Токио хотын нэгэн сургуулийн “Сургууль төвтэй хичээлийн судалгаа” (2009-2011 он)

Энэ сургуулийн хичээл сургалтын зорилт:

“Суралцахуйн баясгалан, Сурч мэдэхийн давуу тал, Эелдэг зан чанар”



Хүүхдийнхээ байдалд судалгаа хийнэ

- Хүмүүстэй харилцах дуртай.
- Өөрийн санаа бодлоо үгээр илэрхийлэх чадвар хангалтгүй.
- Бусдын санаа бодлыг хүлээж авах чадвар сулавтар



Судалгааны сэдвээ сонгох

“Харилцааны чадвар эзэмшүүлэн, санаа бодлоо харилцан илэрхийлэх чадвартай хүүхэд” болгон төлөвшүүлье.



Зөв төлөвшсөн хүүхэд ямар байх ёстойг тодорхойлно

1, 2-р ангийн хүүхэд:

Бусдын үгийг хүлээцтэй сонсон, хэлэх гэсэн зүйлээ эелдэгээр хэлж чаддаг болсон байдаг.

3, 4-р ангийн хүүхэд:

Бусдын үгийг хүлээцтэй сонсон, өөрийн бодлоо үгээр илэрхийлж чаддаг болсон байдаг.

5, 6-р ангийн хүүхэд:

Бусдын үгийг хүлээцтэй сонсон, өөртөө тунгаан бодож, түүнийгээ илэрхийлж чаддаг болсон байдаг.



Судалгааны таамаглалаа дэвшүүлнэ

Багш хүүхдийнхээ “Харилцааны чадварыг хөгжүүлэх”-эд чиглэсэн ажлаа өдөр бүр давтан хийлгэдэг. Ингэснээр, хүүхдийн харилцааны чадвар (ярих, сонсох) хөгжинө.



Бүх ангид зохион байгуулах ажил (1, 2-р ангийн жишээ):

- Япон хэл: Хүүхэд өөрийн санаа бодлоо бичихэд нь хялбар байдлаар урьдчилан бэлтгэсэн цаас ашигладаг.
- Япон хэл: Багш өөрөө “Бусдыг сайн сонсох арга”-ын үлгэр жишээ үзүүлдэг.
- Япон хэл: 3-4 хүүхдийг баг болгон хоорондоо ярилцах цаг өгдөг.
- Өдөр бүр: Өглөөний цуглааны үед хүүхдүүдэд 1 минут үг хэлэх боломж олгодог.
- Өдөр бүр: Нийт сургуулийн цуглааны үеэр захирал багшийн хэлсэн үгийг ойлгосон эсэхийг тодруулдаг.

- Адилхан анги бүлэгт хичээл заадаг багш нар хамтран ажилладаг.
- Сургуулийн захирал, дэд захирал болон бусад багш нараар ажиглалт хийлгэн, хичээлийн судалгаа хийдэг. Энэ үед юуг голчлон анхаарах вэ гэвэл, “Зөв хөгжиж төлөвшсөн хүүхэд ямар байх ёстой вэ?” гэдэгт гол анхаарлаа хандуулах явдал юм.
- Гадны багш нараас (Их дээд сургуулийн багш, мэргэжилтэн, захирлын туршлагатай багш зэрэг) зөвлөгөө авдаг.
- Гадны багш нар болон эцэг эхчүүдийг урин оролцуулж, судалгааны үр дүнгийн уулзалтыг зохион байгуулдаг.

- Японы туршлага гэж яриад байгаа ч ганцхан жишээ л дурьдагддаг.
- Японы туршлагаас суралцсан зүйлээ сайтар судлан эргэцүүлж, Монголын нөхцөлд тохирох байдлаар өөрчилж болно гэсэн үг юм.

Монголын хүүхдүүдийн төлөө
хамтдаа үргэлжлүүлэн
ажиллацгаая.